



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 168,523,800.00 (нэг зуун жаран найман сая таван зуун хорин гурван мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 6 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн саягтын хамт Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
43 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, ТҮҮНИЙ ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Нийт гүйлт (км)	Ашиглалта д орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуризмтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өрөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн							
1	ГАЗ-330/273-418цо, 88-76 УБӨ (арал х9633027372250848)	213563	2007	36,698,000.0	36,698,000.00	-	1,500,000.00
2	УАЗ-326901, соболь цо, 89-87 УБӨ (арал 40082317)	234736	2005	41,680,000.0	41,680,000.00	-	1,500,000.00
3	Газель-32613Н, 42-31 УБИ (арал х8932613h70ск9063)	205463	2007	41,322,000.0	41,322,000.00	-	1,500,000.00
4	Тоёота раум, 59-24 УБН (арал exz100047456)	266486	1998	9,523,800.0	9,523,800.00	-	2,000,000.00
	Дүн			129,223,800.0	129,223,800.0		6,500,000.00
2. Өмнөговь аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба							
1	Тоёота ландкрузер-80, 50-58 ӨМӨ (арал hdj810066823)	245310	1996	36,300,000.0	36,300,000.00	-	2,000,000.00
	Дүн			36,300,000.0	36,300,000.00		2,000,000.00
3. Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба							
1	УАЗ 31512, 1525 ХӨВ (арал 31610030028486)	198731	2003	3,000,000.0	3,000,000.00	-	500,000.00
	Дүн			3,000,000.0	3,000,000.00		500,000.00
	Нийт дүн			168,523,800.00 (нэг зуун жаран найман сая таван зуун хорин гурван мянга найман зуун)			9,000,000.00 (есөн сая)